



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/А54

Булган сум

Бүгд Найрамдах Солонгос Улсын Сэжон
Их сургуулийн оюутны хэлний бэлтгэлийн
сургалтын төлбөрт хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, 2025 оны “Журам шинэчлэн батлах тухай” VIII/56 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүгд Найрамдах Солонгос Улсын Сэжон Их сургуультай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах шалгуурыг хангасан, 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн гэрээний дагуу хэлний бэлтгэлийн хөтөлбөрт элсэн суралцаж буй Жавхлантөгсийн Нандинд сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлсүгэй.

2. Сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай 4,125,000 (дөрвөн сая нэг зуун хорин таван мянга) төгрөгийг “Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрын 2025 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
12 дугаар сарын 01-ний өдрийн
А.Г.СН дугаар захирамжийн хавсралт



**Бүгд Найрамдах Солонгос Улсын Сежон Их сургуулийн
хэлний бэлтгэлийн хөтөлбөрт элсэж, 100 хувийн тэтгэлэгтэй суралцах
оюутны жагсаалт**

д/д	Сумын нэр	Овог нэр	Нэр	Хөтөлбөр	Сургалтын төлбөр (төгрөг)
1	2	3	4	5	6
1	Булган	Жавхлантагс	Нандин	Хэлний бэлтгэл	4,125,000
Нийт үнэ					4,125,000

2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ханшаар 1вон 2,50 төгрөгийн ханшаар бодов.